


## 1.5 Бүтэц зохион байгуулалт

Цогцолборын удирдлага Ерөнхий захирал-1, дэд захирал-2, зохион байгуулалтын бүтэц Хөтөлбөр үйл ажиллагааны алба, Захиргаа санхүүгийн алба, Аж ахуйн алба гэсэн 3 албатай ажиллаж байна.



### УРИА

*Хүн бүрт чин сэтгэлээсээ үйлчилнэ.*

### АЛСЫН ХАРАА

*Олон улсын стандартын шаардлагад нийцсэн, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан үйлчилгээг үзүүлэгч, технологиороо тэргүүлэгч, бүс нутгийн хүүхдийн зуслангуудын шилдэг, загвар байгууллага болох*

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүүхэд бүрийг нийгмийн харилцааны үнэт баялаг, үндэсний ёс заншлаас суралцуулах, хүүхдийн эрхэд суурилсан хөгжлийг дэмжих, тэдний амарч хөгжих, эрүүл, таатай орчинг бүрдүүлэх, чанартай хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх хөгжлийн хөтөлбөрийн арга зүйг дэлгэрүүлэх

### ЗОРИЛТ:

1. Хүүхэд бүрийг нийгмийн амьдралд оролцогч, санаачлагатай, бүтээлч, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, харилцааны ур чадвар, соёлд суралцахад дэмжлэг үзүүлэх
2. Уламжлалт зан заншлыг танин мэдэх, өвлөх болон улс үндэстнүүдийн соёлоос суралцуулан, бие даан амьдрах чадвар, дадал суулгах

3. Хүүхэд амрах, хөгжих эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчинг бүрдүүлэх
4. Хүүхдийн нас, бие сэтгэл зүйн онцлогт тохирсон хөгжил, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх
5. Мэргэжлийн түвшинд ёс зүйтэй ажиллах мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэн тэднийг чадавхижуулах

### **1.5.1 Хөтөлбөр, үйл ажиллагааны алба /46/**

#### **Хөтөлбөр хэрэгжилтийн хэсэг-20**

Цогцолборын сургалт, судалгаа, арга зүй эмнэлэг эрүүл ахуй хариуцсан ажилчид, бүлгийн удирдагч нар зэрэг 20 ажилтан байна. Хөтөлбөр хэрэгжилтийн хэсгийн бүлгийн удирдагчид нь сургалт судалгаа арга зүйн багийн боловсруулсан сүлжээ төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийн дагуу амрагч хүүхдүүдийн дунд 20 гаруй бүлэг, бүлгэмийн болон төрөлжсөн сургалт, хөтөлбөрүүдийг гардан зохион байгуулдаг. Сүүлийн жилүүдэд хүүхдийн дунд нийгмийн харилцаа, байгаль орчин, монгол зан уламжлал, хүүхдийн эрхийн талаарх хөтөлбөрийг түлхүү явуулж байна. Сүүлийн жилүүдэд Монголын хүүхдийн үндэсний чуулган, “Мөнгөн хараацай” урлагийн наадам, Ази номхон далайн орнуудын 31-р жембори, Хүүхэд насанд хүргэж өгдөг галт тэрэг захиалгат ээлж, Эх орон-36 хөтөлбөр, МУЗН-ийн зуслан цугларалт, Мон робот олон улсын тэмцээн, Хүүхдийн зуслан-гэр бүлийн орчин зөвлөгөөн, Соёлын өв уламжлагч хүүхдийн урлагийн наадам, зэрэг үндэсний болон олон улсын хэмжээг амжилттай зохион байгуулсан.

#### **Хоол үйлдвэрлэлийн хэсэг-21**

Тус хэсэг хоолны норм, илчлэгийн байдалд үнэлгээ байнга хийлгэн, хүүхдийн насны онцлог, улирлын байдал, зан заншилд тохирсон хоолны цэс боловсруулан хоол бүрд технологийн карт хөтөлж, хүнсний аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч ажиллан Тогооч нарын холбооны “Итгэмжлэгдсэн хамт олон” өргөмжлөлөөр шагнагдсан. Тус бүр нь 260 хүүхдийн суудалтай өвөл зуны хоолны газар, ажилчдын хоолны газар, 20 хүний суудалтай буудлын зоогийн газартай байна. Хүнсний бараа материалын хангамжийг тендерийн хууль тогтоомжийн дагуу шалгаруулалтаар гүйцэтгэж, зуны улиралд махны хэмжээг бууруулж, сүү, сүүн бүтээгдэхүүн, ногооны хэмжээ, аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүний орцыг нэмэгдүүлэн, хүүхдэд зөв хооллох талаар зөвлөгөөг байнга өгч, хоолны цэсийг 5-10 хоногоор тухайн ээлжийн онцлог, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан зохиож, өдөрт олгож байгаа хоолны илчлэг чанар 2800-3000Ккал байхаар төлөвлөж, өөртөө үйлчлэх үйлчилгээг нэвтрүүлж ажиллаж байна.

#### **Хамтын ажиллагааны хэсэг-4**

Гадаад харилцаа, маркетинг, мэдээллийн технологи, буудлын зохион байгуулагч гэсэн 4 ажилтан тус хэсэгт багтана.

Цогцолборын гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, амрагч хүүхэд, албан байгууллагын хамтарсан сургалт семинарын захиалга авах, хангалт хийх, цогцолборын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, өөрийн орны болон гадаад орны хүүхдийн зуслангуудтай байнгын хамтын ажиллагаатай ажиллан мэдээлэл солилцох солилцооны хөтөлбөрийг Япон, БНАСАУ, БНСУ, ОХУ, БНЭУ, Польш, Канад, АНУ зэрэг орнуудтай амжилттай хэрэгжүүлж байна. Тус цогцолбор нь Олон Улсын Зуслангуудын Холбоо, Азийн Зуслангуудын Холбоо, Монголын Зуслангуудын Холбооны гишүүн байгууллагын хувьд гадаад харилцааг өргөжүүлэх, тэдний ололт амжилтаас суралцах зорилгоор 2007 онд “Дэлхийн хүүхдийн зуслангуудын хөгжлийн чиг хандлага”, 2011 онд “Уур амьсгалын өөрчлөлт... Бид юу хийж чадах вэ?” олон улсын зуслангуудын


хурал, 2012 онд Ази Номхон далайн орнуудын зуслангийн удирдагчдын Анхдугаар сургалт зэрэг олон улсын арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан байна.

### 1.5.2 Захиргаа, санхүүгийн алба /13/

#### Захиргаа, хүний нөөцийн хэсэг-3

Хүний нөөцийн бодлогоор зуны ээлжийн үйл ажиллагаанд Хөтөлбөр хэрэгжилийн хэсэг, Хоол үйлдвэрлэлийн хэсэг, Үйлчилгээний хэсэгт нэмэлтээр 60 ажилтан түр авч ажиллуулдаг болно. Тус цогцолбор нийт 150 ажилтантайгаас нийт ажилтны 31% нь дээд, 41% нь тусгай дунд, 22% нь бүрэн дунд боловсролтой байна.

#### Хүний нөөцийн боловсролын судалгаа



#### Чанар

Тус цогцолбор нь чанарын удирдлагын тогтолцоог төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар бодлого боловсруулж, Чанарын гарын авлага болон байгууллагын стандарт, үйл ажиллаганы процессын удирдлагуудыг боловсруулан мөрдөж ажилласнаар 2011 онд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008/MNS ISO 9001:2010 стандартын шаардлагыг бүхэлдээ бүрэн нэвтрүүлсэн төрийн үйлчилгээний анхдагч байгууллагын гэрчилгээг гардаж авч Стандартчлал хэмжил зүйн газрын 2 удаагийн магадлах аудитаар амжилттай шалгагдсан байна.

Цогцолборын нийгмийн баталгааны хөтөлбөрийг дагуу хамтын гэрээг 10 гаруй жил амжилттай хэрэгжүүлж жил бүр 30-40 сая төгрөгийг ажилтнуудын нийгмийн асуудал, мэргэжил дээшлүүлэх, ахуйн хангамжийг сайжруулахад зарцуулж байна.

Цогцолборын 2020 он хүртэл хугацааны Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласнаар “Хараацай” театр, Сакура хотхон, ажилчдын нэг орон сууц, баримлын хотхон, амрагч тухлах сүүдрэвч, уулзалтын байрыг ашиглалтад орж, Усан спорт цогцолборын барилгын ажил явагдаж байна.

#### Санхүү бүртгэлийн хэсэг-9

Санхүү бүртгэлийн хэсгийнхэн үйл ажиллагаандаа санхүүгийн нөөцийг зөв хуваарилах бодлого баримтлан ажиллаж, аж ахуйн болон хүнсний бараа материал, нүүрс, барилгын засварын материал, эд хогшил худалдан авалтыг тендерийн журмаар зохион байгуулснаар бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, зардал бууруулахад ач холбогдлоо өгч байна.

### 1.5.3 Аж ахуйн алба/88/

#### Дулааны хэсэг-23

Тус цогцолборын дулааны цех нь анх 1981 оны 08-р сарын 06-ны өдөр 034 Гкал/цаг нэгж хүчин чадалтай Братска-1 маркийн 6 зуухтай, 2,04 Гкал/цаг ачаалалтай, сүлжээний к-50/35-, к-90/50 гурван насостай ашиглалтад орж ажиллаж байсан. 1991-1996 оны хооронд 1,5 Гкал хүчин чадалтай

---

ШУХЗ-1,5 маркийн гурван зуухаар шинэчлэгдсэн. 1999 онд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр тус цех нь Цогцолборын мэдэлд шилжин ирснээс хойш 2002 онд буцламтгай үед шаталттай БҮШУХЗ-1,5 маркийн 1 зуух, 2006 онд МЗ-1,5 маркийн 2 зуухыг шинэчилсэн. МЗ-1,5 зуух нь германы технологийн дагуу баригдсан, нарийн тоног төхөөрөмж нь олдоц муу, өөрийн тооцоот хүчин чадлаар ажиллаж чадахгүй байсныг 2008 онд өөрсдийн хүчээр техник технологийн өөрчлөлт хийснээр тооцоот хүчин чадал нь 6Гкал/цаг, боломжит хүчин чадал нь 5,8Гкал/цаг болж сайжраад байна. Одоогийн байдлаар хоногт 72-81Гкал дулаан үйлдвэрлэж, нүүрс 19,5-21,5тн, цахилгаан 1984квт, давс 9кг, ус 4,3тн тус тус зарцуулж байна. 2012 онд дулааны цехийн барилгын өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг төсвийн хөрөнгө оруулалтаар нээлттэй тендер зарлаж 3 зуухыг шинэчилсэн байна.

#### **Харуул хамгаалалтын хэсэг-21**

Тус цогцолборын харуул хамгаалалтын хэсэг нь нийт 20 ажилтантайгаар телекамерийн хяналтын системийг ашиглан 5 пост, нийтийн эзэмшлийн 1500 орчим га талбай, цогцолборын ногоон байгууламжийн 700 га талбай, 1225га эдэлбэр газрын хамгаалалтын үйл ажиллагаа, амрагч хүүхдүүдийн амрах, үйлчилгээний аюулгүй таатай орчинг бүрдүүлэх зорилгоор ажиллаж байна.

#### **Барилга ашиглалтын хэсэг-21**

Тус хэсэг нь цогцолборын хэмжээний бүх барилга байгууламжийн цахилгаан, сантехник болон автомашины тээвэр, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг. Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт барилгын болон инженерийн шугам сүлжээний 30%, цахилгааны тоног төхөөрөмжийн 40%-д их ба урсгал засвар хийж, “Хүүхдийн хөгжил мэдээллийн ордон” -г болгон шинэчлэн засварлаж, хүүхдийн урлаг, соёлын арга хэмжээг явуулах 650 суудалтай “Хараацай” театрыг барьж байгуулан ашиглалтанд оруулсан байна.

Автын хэсгийн 2016 оноос барилга ашиглалтын хэсэгтэй нэгтгэсэн. 11 автомашин, 8 жолооч, 1 диспетчертэйгээр амрагч хүүхдүүд, аж ахуйн үйлчилгээнд түргэн шуурхай, осолгүй үйлчлэх, машин техникийн бэлэн байдлыг хангах, үйлчилгээний орлогыг нэмэгдүүлэх дотоод тооцоогоо улам сайжруулах зорилгоо ханган биелүүлж, жолооч нар хариуцсан машин техникийн үйлчилгээ засварыг цаг тухайд нь хийж, ажиллах ур чадвар нь дээшилж, эвдрэл саатал, үйлчилгээний доголдолгүй ажиллаж байна.

#### **Эрүүл ахуй үйлчилгээний хэсэг-22**

Тус цогцолборын үйлчилгээний хэсэг нь 21 үйлчлэгчтэйгээр нийт 7 объектын 12157м<sup>2</sup> талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажилладаг. 2007 оноос үйлчлэгчдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, мэргэжлийн үнэмлэх, чанарын талонтой болгож, чанарын дугуйлангийн системээр ажилласнаар ажлын хариуцлага, чанар, үр дүн сайжирч хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг 96%-иас бууруулахгүй үйлчилж байна.

---

## **“ЧАНАРЫН БОДЛОГО”**

Цогцолборын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд тасралтгүй явуулж, хүлээн авсан хүүхэд, өсвөр үе, залуучуудыг найдвартай тээврийн хэрэгсэл, амт чанар, илчлэг сайтай, баталгаатай хоол, хүнс, хөгжлийн уян хатан, шилдэг хөтөлбөрөөр хөнгөн шуурхай, эелдэг найрсаг үйлчлэн, эрүүл, аюулгүй орчинд амрааж, хамгийн өндөр сэтгэгдэлтэйгээр үдэх явдал бидний **“ЧАНАРЫН БОДЛОГО”** болно.

Дээрх бодлогын шаардлагыг хангахын тулд бид:

1. Бүрэн хэмжээнд баримтжуулсан чанарын менежментийн тогтолцоог ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандартын шаардлагад нийцүүлэн ажиллуулах болно;
2. Цогцолборын үндсэн үйлчилгээ болох “Хөгжлийн хөтөлбөр”-ийн үр дүнг байнга хянаж, шинэчилж байх болно;
3. Хэрэглэгчид (хүүхэд багачууд)-ийнхээ хүсэл сонирхол, хэрэгцээг байнга судлан, дүн шинжилгээ хийж түүнд нь тохируулж байхыг эрмэлзэх болно;
4. Хэрэглэгчиддээ үйлчлэх тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, хоол, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл чанар, амралтын гаднах орчин, орон байрны нөхцлийг хяналтандаа байнга байлгах болно;
5. Сайжруулах зүйлүүдийг илрүүлэн гаргаж, сайжруулалтын баримтжуулсан тогтолцоог хэрэгжүүлнэ;